

АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

I. ӨРХ, ХҮН АМ: Оны эцэст 15.5 мянган өрх, 54.9 мянган суурин хүн амтай болж, урьд оноос өрхийн тоо 295-аар, хүн амын тоо 489-өөр өслөө. Нийт өрхийн 50.6 хувь буюу хүн амын 52.4 хувь нь хөдөөд амьдарч байна. Нийт өрхийн 73.7 хувь нь гэрт амьдарч байгаа бөгөөд 95.7 хувь нь хувийн өмчийн сууцанд амьдарч байна.

Хүн амын 49.9 хувь нь эмэгтэйчүүд байна.

Нийт хүн амын 67.0 хувийг 15-59 насныхан, 27.7 хувийг 0-14 насныхан, 5.3 хувийг 60 ба дээш насныхан эзлэх болсноор хүн ам зүйн ачаалал 49.3 хувьтай болж, хөдөлмөрийн насны 2 хүнд 1 тэжээлгэгч хүн ногдож байна.

66 багаас хамгийн олон өрх, хүнтэй баг нь Баруун-Урт сумын 5-р баг 822 өрх, 2721 хүнтэй байна.

2010 онд 1218 хүүхэд төрснийг, 239 гэр бүл болсныг бүртгүүлсэн бөгөөд 635 хүн шилжин ирсэн нь урьд оноос 121 хүнээр илүү, 1420 хүн гадагш шилжин явсан нь урьд оноос 11 хүнээр олон байна. Шилжин явагсдын 74.9 хувь нь Улаанбаатар хот руу шилжсэн байна.

II. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 7.4 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 2.6 хувиар давж биелсэн нь урьд оныхоос 3.0 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Бүх сум төсвийн орлогын төлөвлөгөөгөө биелүүлж, дүнгээр 10.5 хувиар буюу 0.2 тэрбум төгрөгөөр давууллаа.

Орон нутгийн төсвийн зарлага 6.5 тэрбум төгрөг болжээ. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт 3.2 тэрбум төгрөгт хүрсний дотор нийгэм бие хүнд үзүүлэх бусад үйлчилгээний салбарт 2.5 тэрбум төгрөг, төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаанд 399.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн нь хамгийн их нь байна.

III. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 19.6 тэрбум төгрөгт хүрсэн нь урьд оны мөн үеийнхээс 6.6 тэрбум төгрөгөөр буюу 50.8 хувар өсчээ.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 11.4 тэрбум төгрөг болж, урьд оныхоос 4 тэрбум төгрөгөөр буюу 54.1 хувиар өссөн байна.

IV. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Малтай болон малчин өрх, малчид: Аймгийн нийт өрхийн 58.9 хувь болох 9.1 мянган өрх аминдаа 1957.9 мянган мал тоолуулсан нь нийт малын 98.9 хувийг эзэлж байна. Малчин өрх 6909, малчдын тоо 15142 болсны дотор 16-34 насны залуу малчдын хувийн жин буурч, 48.2 хувьд хүрлээ.

Нийт малтай өрхийн 67.9 хувийг 200 хүртэл малтай өрх эзлэх болж, энэ үзүүлэлт жил дараалан буурч, харин 200-аас дээш малтай өрхийн тоо өсч, чанарын өөрчлөлт гарч, 219 малчин өрх мянгаас дээш мал тоолуулж, шинээр 77 мянгат малчин төрлөө.

Мал аж ахуй: Мал сүргээ урьд оноос 5 төрөл дээр нь 190.1 мянгаар өсгөж, 1979.8 мянган мал тоолуудсны дотор 10.9 мянган тэмээ, 148.1 мянган адуу, 128.0 мянган үхэр, 961.2 мянган хонь, 731.6 мянган ямаа тоологдлоо.

Түмэнцогт сумаас бусад бүх сумд малаа өсгөсний дотор Сүхбаатар, Эрдэнэцагаанаас бусад 10 сум 5 төрөл дээр нь малаа өсгөлөө.

Харин Түмэнцогт сум шүлхий өвчний үед аймгийн махны хэрэглээг бэлтгэж хангаж байсан нь хонь, ямааны тоо буурахад ихээхэн нөлөөлсөн талтай.

Малын тоог багаар авч үзвэл: 66 багийн 17 нь 40.0 мянгаас дээш малтай байгаагийн дотор хамгийн олон малтай нь Баяндэлгэр сумын 4-р баг 67.6 мянган малаар тэргүүлж байна.

Нийт 858.7 мянган хээлтэгч тоологдсон нь нийт малын 43.4 хувийг эзлэх боллоо.

Оны эхний эх малын 88.9 хувь нь төллөж, гарсан төлийн 94.1 хувь буюу 656.2 мянган төл бойжиж байна.

Оны эхний малын 3.4 хувь болох 60.9 мянган том мал зүй бусаар хорогдлоо.

Газар тариалан: Энэ жил үр тариа 80.0 га-д, төмс 59.0 га-д, хүнсний ногоо 27.96 га-д тариалж, 40.0 тн үр тариа, 437.4 тн төмс, 217.2 тн хүнсний ногоо тус тус хураан авч, төмс, хүнсний урьд оноос 19.4-23.4 хувиар дээгүүр байна.

Хадлан 12.1 мянган тн, гар тэжээл 1677 тн, тэжээлийн ургамал 14.4 тн-ыг бэлтгэсэн нь урьд оноос 30.3-68.3 хувиар дээгүүр байна.

V. БЕЗНИС РЕГИСТРИЙН САН: Бизнес регистрийн санд 463 ААНБ бүртгэлтэй байгаа бөгөөд 421 буюу 90.9 хувь нь тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Бүртгэлтэй ААНБ-ын тоо урьд оноос 11-ээр нэмэгдэж, харин үйл ажиллагаа явуулж байгаа ААНБайгууллага 3-аар буурчээ

Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл: ХХК 45.6 хувь, төрийн байгууллага 31.1 хувь, ЗБН 7.8 хувь, ТББ 3.8 хувь, ББН 6.4 хувь, Хоршоо 4.8 хувийг тус тус эзэлж байна. Өмчийн хэлбэрээр нь авч үзвэл: Хувийн хэвшил 68.9 хувийг эзэлж байна.

VI. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 28.7 тэрбум төгрөг болсон нь урьд оноос 5.2 тэрбум төгрөг буюу 15.3 хувиар доогуур байгаагаас уул уурхай, олборлох аж үйлдвэр 5.4 тэрбумаар буурчээ.

Аж үйлдвэрийн борлуулалт 104.6 тэрбум төгрөгт хүрч, урьд оноос 2.7 тэрбум төгрөгөөр буюу 2.7 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн боов, ул боов, нүүрс, блок, замын хавтан, дулаан үйлдвэрлэлт нэмэгдсэн байна.

VII. БАРИЛГА, ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Нийт 5.7 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийсэн нь урьд оноос 3.2 дахин өссөн байна. Шинээр 14 барилга ашиглалтанд оруулсан байна.

Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 54.9 сая.тн км ачаа эргэлт, 7.2 сая. хүн км-ийн зорчигч эргэлт гүйцэтгэн, 6.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оноос 11.5 хувиар өссөн байна.

Авто тээврийн хэрэгслийн тооллогын дүнгээр 5614 тээврийн хэрэгсэл тоологдсон нь урьд оноос 469-өөр доогуур байгаагийн дотор оношлогоонд 4178 тээврийн хэрэгсэл орсон байна.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 324.1 сая төгрөг байгаагийн дотор хүн амаас 156.7 сая төгрөг орсон нь урьд оноос нийт орлого нь 2.7 хувиар буурч, хүн амаас орох орлого 7.8 хувиар өссөн байна.

VIII. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 9.5 хувиар өссөнд тээврийн салбараас бусад бүх бүлгийн барааны үнэ тариф 0.1-31.3 хувь болтлоо өссөн нь нөлөөлжээ

IX. БОЛОВСРОЛ,СОЁЛ: 2010-2011 оны хичээлийн жилд 367 бүлэгт 10.4 мянган хүүхэд суралцаж байгаагийн 49.9 хувь нь эмэгтэй сурагчид байна.

1-р ангид 1.0 мянган хүүхэд элсэн орж, бага ангид 5.5 мянга, дунд ангид 3.7 мянга, ахлах ангид 1.2 мянган хүүхэд суралцаж байна.

Энэ жил 15 сургуульд 971 хүн ажиллаж байгаагийн 686 буюу 70.6 хувь нь эмэгтэй багш байна.

Урьд оноос нийт сурагчдын тоо 274-өөр буурсан хэдий ч ажиллагсадын тоо 102-оор нэмэгдэж, үүний дөнгөж 5 нь үндсэн багш байна.

ЕБС-ийн нийт ажиллагсадын дотор үндсэн багшийн эзлэх хувь аймгийн дүнгээр 53.5 хувьтай байгаагийн дотор Бүрэнцогт, Тэмүүлэл, 1-р 10 жил, Эрдэнэцагаан сумдад 80.0-59.3 хувь нь үндсэн багш эзэлж байхад Халзан, Түвшинширээ, Наран, Уулбаян сумдад дөнгөж 42.1-43.6 хувь нь үндсэн багш эзэлж, ихэнх нь бусад ажилтнууд байна.

Соёл: 2008 онд 1.8 сая төгрөгийн орлоготой ажиллаж байсан Хөгжимт жүжгийн театр 2010 онд 27.0 мянган үзэгчдэд 86 тоглолтоор үйлчилж 14.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь 2008 оныхоос 800 дахин өссөн байна.

Музей: 1.8 мянган үзмэрээр 1.3 мянган хүнд үйлчилж, 946.5 мянган төгрөгийн орлого олж, 86.0 сая төгрөгийн зардалтай ажилласан байна.

Нийтийн номын сан: 26.4 мянган уншигчдад 42.0 мянган номоор үйлчилж 927.7 мянган төгрөгийн орлого олж, 36.7 сая төгрөгийн зардал гаргасан байна.

XI. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 907 болж, урьд оныхоос 134-өөр буурчээ. Ажилгүй иргэдийн 85.6 хувь нь 16-34 насны залуучууд, 33.5 хувь нь бүрэн дунд, 23.7 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. 2983 хүн шинээр бүртгүүлж, 2650 хүн ажилд орсны дотор 812 нь шинэ ажлын байр байна.

X. ЭРҮҮЛ МЭНД: 1149 эх амаржиж, 1160 хүүхэд төрсөн бөгөөд 1 хүртэлх насандаа 25 хүүхэд эндсэн нь урьд оноос 3-аар олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 591 болж, урьд оноос 313-аар буурсны дотор вируст гепатит, тэмбүү, трихомониаз зэрэг өвчлөлтүүд буурсан байна.

XII. АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН, ОРЛОГО: 3-р улирлын түүвэр судалгаанд хамрагдсан 40 ААНБ-ын ажиллагчдын дундаж цалин, орлогыг авч үзэхэд: Санхүү, уул уурхай, цахилгаан эрчим хүч, тээвэр, холбоо, үл хөдлөх хөрөнгө, төрийн удирдлага, батлан хамгаалахын салбар өндөр үзүүлэлттэй байна.

XIII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 3870.5 сая төгрөг болж төлөвлөгөө 10.4 хувиар давж биелэв. Харин сайн дурын даатгалын шимтгэлийн орлого 96 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 26 хувиар тасарсны дотор Баруун-Урт, Асгатаас бусад сумд тасалсан байна.

6171 өндөр настанд 6.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 1.6 тэрбум төгрөг, улсын төсвөөс 0.8 тэрбум төгрөг иргэдэд олгожээ. 2010 онд хүний хөгжил сангаас иргэн бүрт 120.0 мянга, нийтдээ 54.5 мянган хүнд 5.6 тэрбум төгрөгийг олгосон байна.

XIV. ГЭМТ ХЭРЭГ: Гэмт хэргийн тоо 200 байгаа нь урьд оны түвшинд байна. Гэмт хэргийн улмаас 39 хүн нас барж, 45 хүн гэмтэж, ААНБ, иргэдэд 246.8 сая төгрөгийн хохирол учирсны 231.2 саяг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 191 хүн сэжиглэгдсэний 9.9 хувь нь бүлэглэнгээр, 16.2 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 2672 эрүүлжигдсэн нь урьд оноос 16 хүнээр өсчээ.

XV. ТӨСӨЛ: Малын индексжүүлсэн даатгал төсөл 13 суманд хэрэгжиж 649 өрхийн 119.1 мянган малыг хамруулж, 51.6 сая төгрөгийн хураамж авсан нь урьд оноос өрхийн тоо 2.4 дахин, хураамж 2.9 дахин өссөн байна.

2009 онд МИД төсөлд хамрагдсан Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан сумдын 44 өрхөд 9.9 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон.

Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөлд хамрагдахаар 2.1 тэрбум төгрөгийн 113 төслийг иргэд ирүүлснээс аймгийн дэд комисс, банкны шалгуураар 601.8 сая төгрөгний 46 төсөл батлагдаж санхүүжилтээ авсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 433 төсөлд 389.2 сая төгрөгийн зээл олгосны дотор Эрдэнэцагаан 55 төсөлд 53.6 сая, Баяндэлгэр 53 төсөлд 52.8 сая, Дарьганга 69 төсөлд 51 сая төгрөгийн зээл авсан нь бусад сумдын зээл олголтоос дээгүүр байна.

Тогтвортой амьжиргаа-II төслөөр 284.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдснээс байгууллагын тохижуулалтанд 84.9 сая, засварт 55.5 сая, шинээр 25.5 сая төгрөгийг зарцуулжээ. Мөн бэлчээрийн эрсдлийг бууруулахад 337.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэний дотор шинэ худаг гаргахад 3.7 сая, өвс тэжээлийн агуулах барихад 84.4 сая, сэргээн засварлахад 61.2 сая, бэлчээр, булаг шанд хашиж хамгаалахад 67.7 сая, хадланд 76.7 сая төгрөгийг тус тус олгосон байна.

XVI. ГАЗАР ӨМЧЛӨЛ: Одоогийн байдлаар нийт 5178 иргэн газар өмчилж авахаар өргөдөл гаргаснаас 4947 иргэнд 477.18 га газар өмчлүүлээд байна.

XVII. ДААТГАЛ: Даатгалын кампаниуд 12156 иргэнийг 10 төрлийн даатгалд хамруулан 112.9 сая төгрөгийн хураамжын орлого оруулснаас 675 иргэнд 35.1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.

XVIII. СОНИРХОЛТОЙ СТАТИСТИК: Статистикийн мэдээллийг хэрэглэгч нартаа зориулан аймаг байгуулагдсанаас хойшхи хугацааны өрх, хүн ам, малын тооны хамгийн өндөрт хүрсэн үзүүлэлт, амины малын өсөлт, бууралт, 22 жилийн өмнөх малтай өрхийн малын тооны хязгаар, мянгат малчдын тооны өсөлт зэрэг статистикийн тоон түүхийн зарим сонирхолтой материалыг орууллаа.



Статистикийн хэлтсийн дарга *О.Цэрэндулам* О.Цэрэндулам.